

## ХҮРД ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэнд талархаж, хурлын ажиллагаанд идэвхтэй, ажил хэрэгч оролцохыг хүсч байна.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдийн тоо болон хувь хэмжээнд өөрчлөлт, хөдөлгөөн бараг гарсангүй. 2016 оны 02-р сарын 15-ны байдлаар компанийн 135266 ширхэг хувьцааг 103 хүн эзэмшиж байна.

Тайлант хугацаанд компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан бизнес төлөвлөгөө, удирдлагын зардал, компанийн үйл ажиллагаа, ажиллагсдын цалин жэлс урамшуулал, хөрөнгийн өсөлт бууралт, ногдол ашиг, удирдлагын урамшуулал олгох асуудалд анхаарал хандуулан ажиллаж ирлээ.

Компанийн ТУЗ 10 удаа хуралдаж, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, ногдол ашиг болон удирдлагын урамшуулал олгох, компанийн хэтийн хөгжил, засаглалыг сайжруулахад зориулж шинэ залуу боловсон хүчин бэлтгэх, инженерүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж зэрэг эзэмшүүлэх, мэргэжлийн зэргийг цалин жэлс, ажил үүргийн хуваарьтай уялдуулах, бизнес төлөвлөгөөний биелэлт, компанийн үйл ажиллагаа, барилга угсралтын ажлын явцтай танилцах, барилга угсралтын ажлын санхүүжилтын векселийг худалдах зөвшөөрөл олгох, үрээсийн төлбөрийг шинэчлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэлээ.

2014 онд компанийн нэгж хувьцаанд **273** төгрөг, бүгд **36.9** сая төгрөгийн ногдол ашиг олгосон бол 2015 онд компанийн нэгж хувьцаанд **275** төгрөг, нийт **37.2 сая** төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2014 оны ажлын үр дүнд **"хангалттай"** гэсэн дүгнэлт өгс нийг үндэслэн удирдлагын урамшуулал олгох журмын дагуу ТУЗ болон удирдлагын урамшилд **18,4 сая** төгрөг олгосон.

2015 оны компанийн удирдлагын зардлыг **249,5** сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэл нь **226,9** сая төгрөг болж, **22,5 сая** төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.

2015 онд компанийн чухал хэрэгцээт мэргэжлээр 8 удаагийн сургалтанд 19 хүн хамрагдаж, шинээр буюу мэргэжлийн зэргээ ахиулсан байна. Үүнд : Мэргэшсэн өсөвчин, Х өдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан бэлтгэх, цахилгааны групп зэрэг, цахилгаан гагнуурчдын категорийн сургалт, аттестатчлал, кранчин, дохиочин бэлтгэх, хугацаа сунгуулах зэрэг болно. Эдгээр сургалтанд **6,168** сая төгрөг зарцуулжээ.

Компани санхүүгийн хувьд мөнгөн хөрөнгө, материалын зохих нөөцийг бүрдүүлж, эдийн засгийн хүчин чадал өсөн нэмэгдэж байна.

Компанийн үл хөдлөх хөрөнгө **102.89** сая төгрөг ийн өртөг бүхий бетон эдлэлийн цехийн барилгаар нэмэгдэж, 10 барилга байгууламж **316,04** сая төгрөг байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд **594,5** сая төгрөг байсан бөгөөд доорх өөрчлөлт орсон байна. Үүнд: **46,4** сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хасагдаж, оны эцэст **548,0** сая төгрөг болж буурчээ.

Компани 2015 онд **2 тэрбум 404 сая** төгрөгийн БУА, материал нийлүүлэлтийг гүйцэтгэж, **88,7** сая төгрөгийн материал, бэлэн бүтээгдэхүүн гадагш борлуулжээ. 2015 онд нийт борлуулалт **2,9** тэрбум төгрөг болсон.

БУА, материал үйлдвэрлэл, худалдааны үйлчилгээ эрхэлж, **2 тэрбум 406** сая төгрөгийн борлуулалт хийж, **663,5** сая төгрөгийн ашигтай ажилласнаас компанийн цэвэр ашиг **414,12** сая өгрөг байна. Компанийн хэмжээнд 1 төгрөгийн БУА -ын өөрийн өртөг **85,5** мөнгө байна.

Энэ онд улсын төсөвт төлөх НӨАТ, аж ахуйн нэгжийн ашгийн татвар, хүн амын орлогын татвар, хөдлөх хөрөнгийн, газрын, тээврийн хэрэгслийн татварт **340,3 сая** төгрөг төлж, мөн нийгмийн даатгалын шимтгэлд **105,7** сая төгрөг төлж, улсын татварын өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн байна.

2015 оны бизнес өлөвлөгөөний биелэлт 40 хувь буюу 1 тэрбум 59 сая төгрөгөөр тасарч, харин ашгийн төлөвлөгөө 12,4%-буюу 45,65 сая өгрөгөөр давж биелжээ.

2015 онд томоохон төсөл арга хэмжээ, БУА шинээр авч чадаагүй бөгөөд ОБЕГ-т нийлүүлсэн 1 тэрбум 448,9 сая төгрөгийн үнэтэй хамгаалах хувцасны борлуулалт 2015 онд багтаж санхүүжилт ороогүй нь борлуулалт тасалдахад нөлөөлсөн боловч үүний борлуулалт, ашиг нь 2016 онд тооцогдох болно.

Компани 2015 онд Азийн хөгжлийн банк, Европын Хөрөнгө оруулалтын банк, болон улс, хотын хөрөнгөөр санхүүжих 21 тендерт оролцсоноос 4,43 тэрбум төгрөгийн өртөг бүхий 5 тендерт шалгарч, 2,4 тэрбум төгрөгийн гэрээт ажлыг гүйцэтгэсэн болно.

Азийн хөгжлийн банк, Европын Хөрөнгө оруулалтын банкны хөрөнгөөр санхүүжих Улаанбаатар хотын Сэлбэ гэр хорооллын 2183 м бохир усны шугамын 2 тэрбум өгрөгийн угсралтын ажлыг гэрээг байгуулаад байна. Энэ ажлын тендерт 2015 онд шалгарсан боловч тендерийн хуулийн дагуу удаа дараа гомдол гарч, тендер шалгаруулалт удааширсаар өдийг хүр сэн ч гэрээ байгуулах асуудал шийдэгдээд байна.

Бид өнгөрсөн онд урьд оноос шилжсэн болон шинээр эхэлсэн дараах барилгуудын ажлыг гүйцэтгэж, ашиглалтанд хүлээлгэн өгсөн байна. Үүнд:

1. Азийн хөгжлийн банкны зээлээр санхүүжсэн Говь-Алтай аймгийн Алтай хотын ус хангамж, ариутгах татуургыг сайжруулах МОН-2301 төсөл-Нийт өртөг- 1473,0 сая төгрөг. /2014-2015 онд/
2. Дулааны станцын КВТС-10/150 зуух барих ажил. Улаанбаатар Налайх-2980.9 сая төгрөг /2013-2015 онд/
3. УБ хотын Гэр хорооллын үндэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах Багц-8 ажил-621,9 сая төгрөг. /2015 онд/
4. БЗД-ийн 28-р хорооны айл өрхийн цахилгаан хангамжийг сайжруулах ажил. 10кВ-ын ЦДАШ, 10/0,4кВ-ын дэд өртөө, 0,4кВ-ын ЦДАШ тоолуурын хамт. Багц-3. -188,4 сая төгрөг. /2015 онд/.

5. 1-р хороолол Орбитын чиглэлийн цэвэр усны шугамын цэвэрлэх үзэрийн хаалттай дэд өртөөний тэжээлийн кабель шугам-175,5 сая төгрөг. /2015 онд/
6. Булган аймгийн Хялганат тосгоны бохир усны шугамыг шинэчлэн, баг оврын цэвэрлэх байгууламж барих-348,0 сая төгрөг. /2015 онд/
7. 110/35/10кВ-ын 7-р хороолол дэд станцаас 10кВ-ын Хайлаастын фидерийн ачаалал хөнгөлөх-443,8 сая төгрөг. /2015 онд/
8. 96 магистраль шугамын гадна дулааны шугамын угсралтын ажил- 76,5 сая төгрөг. /2015 онд/

2015 онд урьд оноос шилжсэн Азийн өгжлийн банкны зээлээр санхүүжсэн Говь-Алтай аймгийн Алтай хотын ус хангамж, ариутгах татуургыг сайжруулах МОН-2301 төсөл, Дулааны станцын КВТС-10/150 зуух барих ажил. /Улаанбаатар Налайх/-ыг амжилттай дуусгасан, ОБЕГ-т 1 тэрбум 448 сая төгрөгийн хамгаалалтын хувцса нийлүүлэлт хийсэн нь үр дүнтэй ажил болсон.

Тайлант хугацаанд жилийн дунджаар **78** хүн ажиллаж, **451,6** сая төгрөгийн цалин олгож, компанийн ажилтны сарын дундаж цалин **482,48** сая төгрөг болж, өмнөх / 737,7 мян. төгрөг/ оныхоос **34,6%**-255,27 мянган төгрөгөөр буурчээ.

Ажилчдын дундаж цалин буурсан нь 2015 онд ажлаар нэвддүүрэн хангагдаж чадаагүй, БУА-ын хэмжээ бага байсныг харуулж байна.

Байгууллага хүмүүсээс авах БУА-ын санхүүжилт болон авлага оны эхэнд **2373,4** сая өгрөг байсан бол тайлант хугацаанд **2630,1** сая төгрөгөөр нэмэгдэж, **3897,2** сая төгрөгөөр буурч, оны эцэст авлага **1105,4** сая төгрөг болж, **1268,0** сая төгрөгөөр буурсан байна.

Мөн байгууллага хүмүүст өгөх өглөг оны эхэнд **564,6** сая төгрөг байсан бол тайлант хугацаанд **403,7** сая төгрөгөөр нэмэгдэж, **478,6** сая төгрөгөөр буурч, оны эцэст **489,7** сая төгрөг болж өглөг **74,9** сая төгрөгөөр буурсан байна.

Компанийн өнгөн хөрөнгийн ашиглалтыг сайжруулахад анхаарч, харилцагч банкуудаас харилцахынүлдэгдэлд олгох хүүгийн хувь хэмжээний талаар санал авч, судалгаа хийснийүндсэн дээр харилцахын үлдэгдэл болон хадгаламжид өндөр хүү олгож байгаа Төрийн банкинд мөнгөн хөрөнгийн ихэнх хэсгийг байршуулж, харилцахынүлдэгдэлд жилийн 10,2% буюу сарын 0,85% -тай хүү авч байна. 2015 онд байгууллагын харилцахынүлдэгдл ийн хүү болон хугацаатай хадгаламжийн хүүд нийт 338,1 сая төгрөгийн хүүгийн орлого, мөн валютын ханшны зөрүүгээс 60,48 сая төгрөгийн орлого авсан байна.

БУА-ын урьдчилгаа буюу захиалагчийнөрөнгө оны эхэнд **450,7** сая төгрөг байсан бол оны эцэст **305,7** сая төгрөг болж, **145,0** сая төгрөгөөр буурсан байна.

2015 онд мөнгөн хөрөнгийн ашиглалт, банкны хүүг нэмэгдүүлэх болон авлага, өглөгийг барагдуулах буюу эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд амжилттай ажилласан байна.

Компанийн "Нарлаг" зочид буудал 2015 онд нийт **40,1** сая төгрөгийн орлого олж, **59,3** сая төгрөгийн зардал гаргаж, **-19,2** сая төгрөгийн алдагдалтай

ажилласан байна. Цаашид зочид буудлын ашиглалтыг сайжруулж, ашигтай ажиллуулах шаардлагатайг анхааруулж байна.

Компанийн үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор ашиглалтгүй байсан цехүүдийн байрыг засварлаж, компанийн дэлгүүр, гараж болгосон бөгөөд үйл ажиллагааг нь өргөжүүлж, үр өгөөжтэй ашиглуулах шаардлагатай байна.

Компанийн ашиглалтгүй буюу илүүдэлтэй ажлын байруудыг түрээсээр ажиллуулж, 2015 онд **98,6** сая өгрөгийн түрээсийн орлого оруулсан нь өнгөрсөн оны хэмжээнд байна.

Эдийн засгийн хямрал, валютын ханшны өсөлтийг дагаж 2015 онд бараа, ажил үйлчилгээний захиалга, цар хүрээ багасч, бидний болонүйлчлүүлэгч, түрээслэгч нарын ажил үйлчилгээ, ашиг орлого буурч байгаа нь илт мэдэгдэж байна.

Байр түрээслэгч нараас төлбөрөө төлж чадахгүйд хүрч, байраа буцаах явдал гарах боллоо. Одоо контор, үйлчилгээний байранд хэд хэдэн ажлын байр сул байна.

Улсын хөрөнгө оруулалттай барилгуудын БУА-ын санхүүжилт он дамжин олгогдохгүй хүндрэл учруулж байна.

Түүгээр ч зогсохгүй улсын хөрөнгө оруулалттай барилгуудын санхүүжилтыг он дамжуулан тавих, түүнийгээ цааш нь дур мэдэн сунгах явдал хэвших шинжтэй боллоо. Үүний захиалагч төрийн яамд ямар ч хариуцлага хүлээдэггүй системд шилжлээ.

Өнгөрсөн онд ажлыг нэрвэн хийж, ашиглалтад өгсөн хэд хэдэн томоохон барилгын санхүүжилтын **1,6** тэрбум төгрөг одоо хүртэл олгогдоогүй, хэдийд олгох нь тодорхойгүй байна. Үүнд:

- Баруун-Уртын Элит хорооллын инженерийн шугам сүлжээ -804,9 сая ₮
- 1-р хороолол Орбитын чиглэлийн цэвэр усны шугамын үзвэрийн хаалттай дэд өртөөний тэжээлийн кабель шугам-175,6 сая төгрөг
- Булган аймгийн Хялганат тосгоны бохир усны шугамыг шинэчлэн, баг оврын цэвэрлэх байгууламж барих-153,3 сая төгрөг.
- Дулааны станцын КВТС-10/150 зуух барих ажил. Улаанбаатар Налайх-409 сая төгрөг
- Хайлаастын фидерийн ачаалал хөнгөлөх ажил-100 сая төгрөг

Түүнээс гадна гүйцэтгэсэн барилга угсралтын ажлын чанарын баталгаанд гэрээний үнийн дүнгийн 10%-тай тэнцэх мөнгөн хөрөнгийг 3 жилийн хугацаатай барьцаалж байгаа нь эдийн засгийн хямрал, валютын ханшны өсөлтөд давхар нэрвэгдэх хүндрэл бий болгоод удаж байна.

Саяхан шинээр батлагдсан Барилгын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд энэ заалт өөрчлөгдөж, чанарын баталгааны барьцаа үр өнгийн хугацаа 1 жил болсон бөгөөд хэрэгжилтийг нь хүлээн сууна.

Энэ нь барилгын байгууллагын эдийн засгийн хүндрэлийг хөнгөлөх үр дүнтэй шийдвэр болсон бөгөөд бид ашиглах, хэрэгжүүлэх тал дээр анхаарах нь чухал юм.

2015 онд компанийн улирал, жилийн тайлан балансыг хугацаанд нь гаргаж, Аудитын байгууллагаар хяналт хийлгэж, Монголын өрөнгийн бирж,

Санхүүгийн зохицуулах хороо, Дүүргийн татвар, санхүүгийн хэлтэст тушааж ажиллаж байна.

"Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай" хуулиар 2014 оны тайлан балансыг шинэчлэн гаргаж мэдүлснээр борлуулалт 7 ,29 тэрбум төгрөг байснаа 11,65 тэрбум болж өөрчлөгдлөө.

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн дагуу төрөөс олгосон боломжийг үр дүнтэй ашиглаж чадсанаар компанийн санжүгийн чадвар нэмэгдэх, цаашид татварын дарамтад өртөхгүй байх нөхцөл бүрдсэн болно.

Компанийн үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлт, 2015 оны бизнес төлөвлөгөөний биелэлт, ТУЗ-ийн үйл ажиллагаа тогтворжсон зэргээс харахад компанийн ТУЗ, үйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хэвийн явагдаж, үүргээ биелүүлж ажилласан гэж үзэж байна.

2016 онд компанийн зорилтотүйл ажиллагааны бизнес төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Энэ оны ажлын ерөнхий чиглэл, зорилго дараах байдалтай байна. Үүнд:

2016 онд компани нийт **4.69** тэрбум төгрөгийн ажил үйлчилгээ гүйцэтгэх ба үүнээс **3,22** тэрбум төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэнэ.

2016 онд одоогоор хэрэгжүүлэх нь тодорхой байгаа доорх ажлууд байна. Үүнд:

- Онцгой байдлын албанд хувцас хэрэглэл нийлүүлэх -840,0 сая төг.
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын авто замын дагуух гэрэлтүүлгийн ажил-250,0 сая,
- СХД.7-р хороо.Овооны 1-3,Баянхошууны 12,21,23 дугаар гудамжны гэрэлтүүлгийн ажил - 126,8 сая төгрөг,
- Сэлбийн 2183м DN400 мм-ийн зөөлөн ширмэн хоолойтой өөрийн урсгалтай ариутгах татуургын шугамын барилгын ажил-2 тэрбум төгрөг

Мөн нэмж хэд хэдэн ажлын тендерт оролцож байгаа бөгөөд цаашид БУА, бараа материал нийлүүлэх чиглэлээр зүгээр суухгүй нь мэдээж, анхаарал тавин ажиллах болно.

Энэ онд дээрх **3,22** тэрбум өгрөгийн барилга угсралтын ажлыг хугацаанд нь чанартай г йцэтгэж, улсын комиссүлээлгэн өгөх үүрэг хариуцлага оногдож байна.

2016 онд Бизнес төлөвлөгөөгөөр **4.69** тэрбум төгрөгийн борлуулалт, **383,8** сая төгрөгийн цэвэр ашигтай байхаар төлөвлөсөн.

2016 онд барилга угсралтын ажлаа гүйцэтгэхээс гадна компанийн гадаад харилцааг хөгжүүлэх, гадаадын түнштэй хамтарсан сантехникийн материалын худалдаа эрхлэх, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, орон сууц барих ажлыг эхлүүлэх, цаашид үргэлжлүүлэх бодлого боловсруулж ажиллана.

Компанийн бетон эдлэлийн боловмөр хийцийн цехийг бие даасан үйлдвэр ХХ Компани болгосон. Тэд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бие даасан ажиллагааг хэрэгжүүлэх, ашигтай ажиллах шаардлагатай боллоо.

2015 онд Баянзүрх дүүргийн 30 машины гаражийн барилгын суурин дээр цэцэрлэг бүхий 15 давхар 98 айлын орон сууцны барилгын ус, дулаан, цахилгаанаар хангах техникийн өмжцөл, зөвшөөрлийг аваад одоо барилгын суурийн ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажилдаа ороод байна.

Компани нийт 5800м<sup>2</sup> талбай бүхий 1 давхартаа цэцэрлэгтэй 15 давхар 98 айлын орон сууц барьж, 2017 онд ашиглалтад оруулна. Орон сууц барихад 6450,0 сая төгрөгийн хөрөнгө шаардлагатай байгаа.

Компани 2015 онд **2 тэрбум 406** сая төгрөгийн БУА, ажилүйлчилгээ гүйцэтгэж, **2,9** тэрбум төгрөгийн борлуулалт хийж, **414,2** сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Энэ нүйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн түвшинд явагдаж, санхүүгийн тогтвортой байдлаа хадгалж, төлөвлөгөөт зорилтуудаа амжилттай биелүүлснийг харуулж байна.

Хэдийгээр компани 2015 онд зохих ашигтай ажилласан боловч цаашид үүсч болох хүндрэл, санхүү хөрөнгө оруулалтын эрсдэлээс сэргийлэн хэмнэлтийн хатуу горимд ажиллах шаардлагатай байна.

Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүнд өөрчлөлт байхгүй тул улируулан үргэлжлүүлж ажиллах саналтай байна.

Улсын хэмжээнд ус, дулаан, цахилгааны зардалд өмнөнийг харгалзан 2016 оны удирдлагын зардлыг өмнөх оны зардлаас 15 % -аар өсгөн **261,3 сая** төгрөгөөр төлөвлөж байна.

Ажлын үр дүн, компанийн 2015 оны үйл аж иллагаа болон санхүүгийн тайланд хангалттай гэсэн дүгнэлтийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл өгч хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Мөн 2016 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлуулахаар хуралд хэлэлцүүлж байгаад санал бодлоо илэрхийлж баталж өгөхийг хүсье.

Та бүхэнд эрүүл энх, ажлын амжилт хүсэн ерөөе.

Хүрд ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл  
2016.04.11